

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр “Корпорейт хотел энд конвеншн центр” зочид буудлын хурлын танхимд компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн 91,52 хувийн оролцоотойгоор хуралдлаа.

Хуралд:

- Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн ажил, Засаглалын тайланг мэдээлэх.
- Компанийн дүрмийн зарим заалтанд өөрчлөлт оруулан шинэчлэн батлах.
- Компанийн ТУЗ-ийн 2018 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
- Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл зэргийг хэлэлцэж шийдвэр гаргалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж үндсэн үүргээ биелүүлсэн ажлын амжилтаар:

- Дархан-Уул аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимаас “УУЛ УУРХАЙН ЭНТЕРПРЕНЕР-2017”
- Дархан-Уул аймгийн Ажил олгогч эздийн холбооны нэрэмжит уул уурхайн салбарын “ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА” өргөмжлөл
- Шарын гол сумын “ОНЫ ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА” –аар өргөмжлөгдсөн
- 2016, 2017 оны ажлын амжилтаар Монгол улсын Засгийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас шалгаруулдаг “ҮНДЭСНИЙ ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖ”-д шалгарлаа.

Гэвч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зохих түвшинд явагдсан ч санхүүгийн үйл ажиллагаанд Европын сэргээн босголтын хөгжлийн банкнаас авсан зээлийн гэрээний үндсэн үүргээ бүрэн биелүүлж чадаагүйгээс компанийн санхүүгийн байдал зохих түвшинд хүрээгүй нь компанийн эдийн засгийн үзүүлэлтэнд сөрөг нөлөөтэй байсныг онцлон тэмдэглэлээ.

Дээрхи байдалд дүгнэлт хийж 2018 онд өмнөх амжилтаа бататган улам эрчимтэй ажиллаж санхүүгийн үзүүлэлтийг сайжруулан цаг үеийн хүндрэлийг даван гарах нь бидний үндсэн зорилт байх ёстой гэж үзлээ.

- Компанийн дүрмийн 9.3 дахь заалтыг компанийн тухай хуулийн хүрээнд өөрчлөлт оруулан шинэчлэн баталлаа.

- Компанийн санхүүгийн байдалтай уялдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны цалин урамшуулал, зардлын төсөвийн хэмжээг өмнөх оныхоос тодорхой хэмжээгээр бууруулж баталлаа.

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр: Жеймс Пассин, Б.Батмөнх, Б.Батбаатар, Казин Ник, Б.Итгэл, Ж.Эрдэмбилэг нарыг,

Хараат бус гишүүнээр: Д.Байлхүү, Н.Батсүрэн, Г.Хулан нарыг сонгож баталлаа.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Харилцах утас: 976-11-311073, 99293913, 99031917